



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/123

Улаан-Уул

Бүх нийтийн их цэвэрлэгээ
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 09 дүгээр зүйлийн 9.4.3, 9.4.5, 9.5.2, 10 дугаар зүйлийн 10.2.6, 10.2.10 дахь заалтууд, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.4 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Даваа гаригт “Бүх нийтийн цэвэрлэгээ”-ний өдөр болгон зарласугай.

2.Тухайн өдөр албан байгууллага, аж ахуй нэгж, айл өрх, иргэдийн оролцоотойгоор нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, нэгдсэн хогийн цэгт хүргэхийг Байгаль хамгаалагч (Ж.Машбат), (Г.Идэрмөнх) 6 дугаар багийн Засаг дарга (Г.Нямдаваа), Жолооч (Б.Амарсанаа) нарт үүрэг болгосугай.

3.Бүх нийтийн цэвэрлэгээний ажилд ард иргэдийг татан оролцуулах, байгууллагынхаа ажилтан албан хаагч нарыг бүрэн хамруулж оролцуулахыг байгууллагын дарга, эрхлэгч, багийн Засаг дарга, хөрш айлын ахлагч нарт даалгасугай.

4.Гарах зардлыг байгаль орчны сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (Ч.Батдорж)-д зөвшөөрсүгэй.

5.Дээрх ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Т.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.



ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

642201253